

өдөр тутмын хэрэглээний
хятад хэл



每日汉语

蒙古语 03



国家汉办/孔子学院总部
Hanban/Confucius Institute Headquarters



中国国际广播电台
CHINA RADIO INTERNATIONAL

中国国际广播出版社

өдөр тутмын хэрэглээний
хятад хэл
每日汉语



目录 / гарчиг

第 22 课 在服装店

22-р хичээл Хувцасны дэлгүүрт..... 1

第 23 课 在商场

23-р хичээл Дэлгүүрт..... 14

第 24 课 在书店

24-р хичээл Номын дэлгүүрт..... 27

第 25 课 问路

25-р хичээл Зам асуух..... 41

第 26 课 乘汽车

26-р хичээл Нийтийн тээврээр
үйлчлүүлэх..... 54

第 27 课 乘出租车

27-р хичээл Таксийгаар үйлчлүүлэх..... 67



目录 / гарчиг

第 28 课 乘火车

28-р хичээл Галт тэргээр аялах..... 78

第 29 课 乘飞机

29-р хичээл Нисэх онгоцонд суух тухай..... 89

第 30 课 驾车旅行


30-р хичээл Авто машинаар аялах..... 101

第 31 课 汉语特点简介

31-р хичээл Хятад хэлний онцлогийн
тухай товч тайлбар 114

第 22 课 在服装店

22-р хичээл Хувцасны дэлгүүрт



Н: Сайн байцгаана уу? Эрхэм найз нараа. “Өдөр тутмын хэрэглээний Хятад хэл”-ний хичээлээр Номиннарс тантай мэндчилж байна.

М: Сайн байцгаана уу? Мөнхөө тантай мэндчилж байна.

Н: Өмнөх хичээлээр бид утсаар бараа худалдан авах тухай ярьж сурсан. Тийм биз, Мөнхөө?

М: Тиймээ, тийм. Би бас пицца захиалсан шүү дээ. Үнэхээр догь юм. Би одоо дэлгүүр явах хэрэггүй, утсаар л бүх юмаа зохицуулах болж байна.

Н: Тиймээ, Мөнхөө. Залгаад бид өмнөх хичээлээр сурсан өгүүлбэрүүдээ давтацгаая. 1-р өгүүлбэр: 我要订个比萨饼.

М: 我要订个比萨饼.

Н: 要订, захих.

М: 要订.

Н: 比萨饼, пицца.

М: 比萨饼.

Н: 怎么付钱呢? Мөнгийг нь яаж төлөх юм бэ?

М: 怎么付钱呢?

Н: 付钱, мөнгө төлөх.

М: 付钱.

Н: 可以货到付款. Бараагаа авсны дараа мөнгөө төлж болно.

М: 可以货到付款。

Н: 货, бараа.

М: 货。

Н: 付款, мөнгө төлөх.

М: 付款。

Н: 你说一个时间。Чи цагаа тогт.

М: 你说一个时间。

Н: За. Одоо бид өмнөх хичээлээр сурсан нэгтгэсэн ярианы дасгалаа бүрэн бүтнээр нь сонсоцгооё.



完整对话 Нэгтгэсэн ярианы дасгал

对话一 Ярианы дасгал нэг

А: 喂, 你好。我要订个比萨饼。Байна уу? Сайн байна уу? Би нэг пицца захиалъя.

В: 大的还是小的? Томыг уу? Жижгийг үү?

А: 大的。Томыг.

对话二 Ярианы дасгал хоёр

А: 怎么付钱呢? Мөнгийг нь яаж төлөх юм бэ?

В: 可以货到付款。Юм нь ирсний дараа мөнгөө төлж болно.

А: 请送到北京大学西门吧。Бээжин их сургуулийн баруун хаалганд хүргээрэй.

В: 好的。За.

能打折吗? Хямдралтай юу?

М: Би нутаг буцахаараа ижийдээ Чи Пао аваачиж өгье гэж бодож байна. Энэ нь Хятадын эмэгтэйчүүдийн уламжлалт хувцасны нэг төрөл юм. Чи Паог Хятадын шинэ хувцасны соёлын дотор өвөрмөц онцлогтой нэгэн төрөл гэж хэлэхэд илүүдэхгүй. Энэ бэлэг ижийд маань их таалагдах байх гэж би бодож байна.

Н: Тэгвэл чи үйлчлэгчид хандаж ингэж хэлж болно: 我想买一件旗袍. Би нэг Чи Пао худалдан авъя.

М: 我想买一件旗袍.

Н: 我, би.

М: 我.

Н: 想, бодох.

М: 想.

Н: 买, худалдан авах.

М: 买.

Н: 一, нэг.

М: 一.

Н: 件, ширхэг.

М: 件.

Н: 旗袍, Чи Пао.

М: 旗袍.

Н: 我想买一件旗袍.

М: Би Чи Пао худалдан авмаар байна.

对话一 Ярианы дасгал нэг

А: 您要买什么衣服? Та ямар хувцас авмаар байна?

В: 我想买一件旗袍。Би Чи Пао худалдан авмаар байна.

М: Номою. Би хэрэв, тэр Чи Паог ямар материалаар оёсон юм бэ? гэж асуух гэвэл хятадаар юу гэж хэлэхийг надад зааж өгөөч.

Н: Та ингэж хэлж болно: 这是什么料子的? Үүнийг ямар материалаар хийсэн бэ?

М: 这是什么料子的?

Н: Мөнхөө маань маш зөв хэллээ. 这, энэ.

М: 这.

Н: 是, бол.

М: 是.

Н: 什么, ямар.

М: 什么.

Н: 料子, материал.

М: 料子.

Н: 的, “-ийн -ын -ны -ний” гэсэн нөхцөлтэй адил. Энэ нь хамаатуулах санааг илтгэжээ. Энгийн байдалд ямар ч бие даасан утгагүй.

М: 的.

H: 这是什么料子的?

M: Үүнийг ямар материалаар хийсэн юм бэ?

对话二 Ярианы дасгал хоёр

A: 这是什么料子的? Үүнийг ямар материалаар хийсэн юм бэ?

B: 真丝的。Силк.

H: 什么, ямар.

M: 什么。

H: 料子, материал.

M: 料子。

H: 这是什么料子的?

M: Үүнийг ямар материалаар хийсэн юм бэ?

M: Тэгэхдээ ямар өнгийнхийг авбал зүгээр юм бол? Хөх нь дээр үү? Шар нь дээр үү?

H: Мөнхөө, Хятад найзуудаасаа асуугаад үз л дээ. Тэд юу гэдэг бол? Аль эсвэл үйлчлэгчид хандан ижийгийнхээ царайны өнгө төлөв зэргийг хэлээд ямар өнгө зохихыг асуухгүй юу? Чи ингэж хэлж болно: 蓝色的好还是黄色的好? Хөх нь дээр үү? Шар нь дээр үү?

M: 蓝色的好还是黄色的好?

М: Хөх нь дээр үү? Шар нь дээр үү?

Н: 能试试吗? Өмсөж үзэж болох уу?

М: 能试试吗?

Н: 能, болох, чанах.

М: 能。

Н: 试穿, өмсч үзэх.

М: 试穿。

Н: 吗, уу? үү?

М: 吗。

Н: 能试试吗?

М: Өмсөж үзэж болох уу?

对话四 Ярианы дасгал дөрөв

А: 能试试吗? Өмсөж үзэж болох уу?

В: 您穿什么号的? Та хэдэн размеровхыг өмсдөг юм бэ?

А: 中号的。М размер.

М: Номио, намайг дэлгүүрээр явж байхад нэг хувцас их таалагдаад, ямар үнэтэй юм? хямдралтай юу? гэж асуух гэвэл хятадаар яаж хэлэх юм бэ?

Н: Та үйлчлэгчээс ингэж асуугаарай: 能打折吗? Хямдруулж болно уу?

М: 能打折吗?

Н: 能, болох, чадах.

М: 能。

Н: 打折, хямдруулах.

М: 打折.

Н: 吗, асуух сул үг.

М: 吗.

Н: 能打折吗?

М: Хямдруулж болох уу?

对话五 Ярианы дасгал тав

А: 多少钱? Ямар үнэтэй юм бэ?

В: 九百八十元. Есөн зуун наян юань.

А: 太贵了. 能打折吗? Яасан үнэтэй юм бэ? Хямдруулж болох уу?

В: 可以打九折. 10% -иар хямдруулж болно.

Н: Өнөөдөр бид хэрэглээний их олон хэл хэллэгээс сурлаа. Хичээл өндөрлөхөөс өмнө амжиж өнөөдрийн чухал өгүүлбэрүүдээ эргэн саная.

М: За, тэгье.

Н: 我想买一件旗袍. Би Чи Пао авмаар байна.

М: 我想买一件旗袍.

Н: 旗袍, Чи Пао.

М: 旗袍.

Н: 这是什么料子的? Энэ ямар материалаар хийсэн

юм бэ?

M: 这是什么料子的?

H: 蓝色的好还是黄色的好? Хөх нь дээр үү? Шар нь дээр үү?

M: 蓝色的好还是黄色的好?

H: 能试试吗? Өмсөж үзэж болох уу?

M: 能试试吗?

H: 能打折吗?

M: Хямдруулж болох уу?

H: Эрхэм найз нараа, залгаад бид өнөөдрийн сурсан нэгтгэсэн ярианы дасгалаа сонсоцгооё.



完整对话 Нэгтгэсэн ярианы дасгал

对话一 Ярианы дасгал нэг

A: 您要买什么衣服? Та ямар хувцас авмаар байна?

B: 我想买一件旗袍。Би Чи Пао авмаар байна.

对话二 Ярианы дасгал хоёр

A: 这是什么料子的? Үүнийг ямар материалаар хийсэн юм бэ?

B: 真丝的。Силк.

对话三 Ярианы дасгал гурав

A: 蓝色的好还是黄色的好? Хөх нь дээр үү? Шар нь

дээр үү?

В: 蓝色的更适合您。Хөх өнгийнх нь өөрт чинь илүү зохиж байна.

对话四 Ярианы дасгал дөрөв

А: 能试试吗? Өмсөж үзэж болох уу?

В: 您穿什么号的? Та ямар размеровхыг өмсдөг юм?

А: 中号的。М размеровхыг.

对话五 Ярианы дасгал тав

А: 多少钱? Ямар үнэтэй юм бэ?

В: 九百八十元。Есөн зуун наян юань.

А: 太贵了。能打折吗? Яасан үнэтэй юм бэ? Хямдруулж болно уу?

В: 可以打九折。10% -иар хямдруулж болно.

М: Өнөөдрийн хичээл энд хүрээд өндөрлөж байна. Одоо Хятадын соёлын тухай танилцуулъя.



Хятадын соёлын тухай

Улаан өнгө бол Хятад соёлд шүтдэг үндсэн өнгийн нэг юм. Энэ нь Хятад хүмүүсийн үзэл санаа, гал халуун эрмэлзлийг харуулж байдаг. Энэ нь өлзий дэмбэрэл,

баяр баясгалангийн бэлэг тэмдэг болдог. Жишээлбэл жил цагаан сар, баяр наадам болоход газар болгонд улаан дэнлүү өлгөнө. Шинэ бэр мордохдоо улаан хувцас, улаан шаахай өмсч, улаан сүйхэнд суудаг. Энэ нь мөн урагштай, амжилттай байхыг бэлэгддэг. Жишээлбэл өөдлөн мандаж байгааг, дээд давхаргын итгэлийг олсон хүнийг, олз ашгаа хуваахыг бүр улаантай холбож хэлдэг. Энэ нь бас гоо үзэсгэлэнг бэлэгддэг. Жишээлбэл эмэгтэй хүний хүндэтгэлийн гоё хувцсыг “Улаан засал”, “Улаан өмсгөл” гэж, эмэгтэй хүний гоо үзэсгэлэнг ч мөн улаантай холбож хэлдэг.

Эрхэм найз нараа. Өнөөдрийн хичээл өндөрлөх гэж байна. Хичээл тарахаас өмнө та бүхэнд нэг асуулт үлдээе. “Хямдруулж болох уу?” гэдгийг хятадаар юу гэж хэлэх вэ?

Энэ асуултын хариуг та mon@cri.com.cn гэсэн хаягаар бидэнд И-мейл бичиж ирүүлээрэй. Энэ хичээлийг дахин сонсохыг хүсвэл та <http://mongol.cri.cn> гэсэн хаягаар манай вэб сайтаар зочлоорой. “Өдөр тутмын хэрэглээний Хятад хэл”-ний хичээлээр уулзтал түр баяртай. 再见!